



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 02 өдөр

Дугаар А/751

Булган сум

Аймгийн Ерөнхий архитекторын ажлыг
хүлээлцүүлэх ажлын хэсэг байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Хот байгуулалтын тухай хуулийн 9 дүгээр зүйл, аймгийн Засаг даргын 2023 оны Б/102 захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Ерөнхий архитекторын ажлыг хүлээлцэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

- Ахлагч: Г.Давааням (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга)
- Гишүүд: Г.Гантулга (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн Газрын харилцаа, харилцаа холбооны бодлого хариуцсан мэргэжилтэн)
Д.Гантуяа (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын хүний нөөц, хуулийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн)

2.Ажлыг 2023 оны 11 дүгээр сарын 07-ны дотор хүлээлцүүлж, танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Г.Давааням)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ